



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/550

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7<sup>1</sup>.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар албан даалгавар /Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах/-ыг хэрэгжүүлэх, ковид-19 халдвар тархалтын үед иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 2 дугаар 60, 24-н айлын орон сууцнуудын болон 7 дугаар цэцэрлэгийн хэрэгцээний халуун усны шугам шинэчлэх болон дулааны узелийн холбох хэрэгсэл тоноглоход 14 010 656, Гаалийн 12 айлын орон сууцны барилгад хэрэглээний халуун усны бойлиур тавихад 8 000 000, Алтайн буйлаастын байрны гадна холигч насосны узелийг авч ГЦЦЭ, Алтайн буйлаастын байрнуудын гадна нэгдсэн худганд холигч насосны узель шилжүүлж угсрах ажилд 12 000 000, Зам засварын ажилд 13 989 344 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнүүдэд зарцуулах 48 000 000 төгрөг /дөчин найман сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.9-д Мал угаах ванн, худаг /Буянт сум, Нарийнгол баг/-ийн үлдэгдэл, 3.52-д тусгагдсан Явган хүний зам засвар /хэрэгжээгүй/-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

2.

3. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/ нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ